

Улсын харъяа бага, дунд сургуульд гадаад хүүхэд элсүүлэх тухай

* Зарим хэсэгт зөвхөн япон хэл дээрх цахим URL хаяг оруулсан болно.

Япон улсын ерөнхий боловсролын тогтолцооны тухай

Ихэнх сургууль

Гадаад улсын хүүхэд ч улсын бага, дунд сургуульд элсэж орох хүсэлт гаргах тохиолдолд, Япон улсын хүүхэдтэй адилаар үнэгүй суралцаж болох бөгөөд, япон улсын иргэнтэй адил сурч боловсрох эрхтэй.

Япон улсад 6 нас хүрсэн жилийн эхний 4 сард бага сургуульд элсэн орох боломжтой байдаг ба 6 жил суралцдаг. Бага сургуулиа төгсөөд дунд сургуульд элсэн орох боломжтой бөгөөд 3 жил суралцана.

<Элсэн суралцагч олонтой 5 улс болон Япон улсын суурь боловсролын тогтолцооны харьцуулалт>

Улсын нэр	Япон	Хятад	Солонгос	Вьетнам	Филиппин	Непал
Хичээлийн жил	4 сар	9 сар	3 сар	9 сар	6 сар	4 сар
5 нас						Бага сургууль (5 жил)
6 нас	Бага сургууль (6 жил)	Бага сургууль (6 жил)	Бага сургууль (6 жил)	Бага сургууль (5 жил)	Бага сургууль (6 жил)	
7 нас						
8 нас						
9 нас						
10 нас						Бага дунд сургууль (3 жил)
11 нас	Дунд сургууль (3 жил)	Бага дунд сургууль (3-4 жил)	Дунд сургууль (3 жил)	Доод ангийн дунд сургууль (4 жил)	Дунд сургууль (4 жил)	
12 нас						
13 нас						Дунд сургууль (2 жил)
14 нас	Ахлах сургууль, гэх мэт	Дээд зэргийн дунд сургууль	Энгийн/ мэргэжлийн ахлах сургууль	Дээд ангийн дунд сургууль	Ахлах дунд сургууль (2 жил)	
15 нас						
16 нас						Ахлах сургууль (2 жил)
17 нас	Их сургууль, мэргэжлийн сургууль, гэх мэт	Их сургууль, мэргэжлийн сургууль	Их сургууль, мэргэжлийн их сургууль	Их сургууль, коллеж	Их сургууль, коллеж, дунд боловсролын дараах сургууль	
18 нас						
19 нас						Их сургууль
}						

* Эх үүсвэр: [Боловсрол, соёл спорт, шинжлэх ухааны яам \(Дэлхийн сургуулийн схем\)](#)

* Өнгөтэй хэсэг нь суурь боловсрол.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, сурагчдийн сургууль (тусгай сургууль) ч бий.

Дэлгэрэнгүйг [Токио хотын боловсролын зөвлөл \(Тусгай сургуулийн жагсаалт\)](#)-н цахим хуудаснаас харна уу.

Мөн, улсын сургуулиас гадна, олон улсын сургуулиуд ч бий.

Хичээлийн нэг жил

Хичээлийн шинэ жил 4 сард эхэлнэ.

	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар
3 улирал	Хаврын амралт	1-р улирал			Зуны амралт	2-р улирал			Өвлийн амралт	3-р улирал		Хаврын амралт		
2 улирал	Хаврын амралт	1-р улирал			Зуны амралт	1-р улирал		2-р улирал		Өвлийн амралт	2-р улирал		Хаврын амралт	

Хичээлийн 1 жилийг 2 хэсэгт хуваасан 2 улиралтай сургууль байхаас гадна, 3 хэсэгт хуваасан 3 улиралтай сургууль ч байдаг.

Улсын бага сургууль, дунд сургуулийн сургалтын төлбөр зэргийн тухай

Сургалтын төлбөр болон сурах бичиг үнэгүй байдаг. Хичээлийн хэрэгсэл (сургууль дээр хэрэглэх материал) зэрэг зарим нэг зүйлд төлбөр гардаг.

Төлбөр мөнгөний асуудлаас болж сургуульдаа явах боломжгүй байх тохиолдолд, хичээлийн хэрэгсэл авах тэтгэлэг авах боломжтой.

Дэлгэрэнгүйг [Токио хотын боловсролын зөвлөл \(Сургалтын тэтгэлэг\)](#)-н цахим хуудас болон [Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухааны яам \(Сургалтын тэтгэлэг\)](#)-н цахим хуудаснаас харна уу.

Улсын дунд сургуулийн оройн анги

Суурь боловсролоо дүүргэж чадаагүй болон дунд сургуульдаа сайн суралцаж чадаагүй хүнд элсэлтийн зөвлөгөө өгдөг.

Токио хотод нийт найман оройн дунд сургууль байдаг.

Дэлгэрэнгүйг [Токио хотын боловсролын зөвлөл \(Улсын дунд сургуулийн оройн анги\)](#)-н цахим хуудаснаас харна уу.

Ахлах сургуульд элсэн орох тухай

“Токио хот дахь гадаад сурагчдын сонгон шалгаруулалт” гэх мэт гадаад улсаас эх орондоо эргэж ирсэн япон хүүхэд болон гадаад улсын харъяа хүүхдэд тусгай анхаарал хандуулдаг.

Дэлгэрэнгүйг [Токио хотын боловсролын зөвлөл \(Хотын ахлах сургууль\)](#)-н цахим хуудаснаас харна уу.

Гадаад хүүхэд элсэн суралцах тухай

Захиргаанд бүртгүүлэх

Гадаадын харъяа хүүхдийн асран халамжлагч нь эхлээд оршин суугаа газрынхаа хот дүүргийн захиргаанд бүртгүүлэх хэрэгтэй.

Бүртгэл байнга явагддаг.

[Хот, дүүргийн засаг захиргааны нэг цонхны үйлчилгээний талаар эндээс харна уу.](#)

Асран халамжлагчид чиглэсэн холбоос

Сургалтын тухай зөвлөгөө авах

- [Боловсролын зөвлөгөө өгөх төв](#)

(1) Сургалтын тухай ерөнхий зөвлөгөө авах, дээрэлхэлтийн тухай зөвлөгөө хотлайн

Утас: 0120-53-8288 (24 цаг, 365 өдөр: үнэгүй)

* Үндсэндээ япон хэлээр харилцана.

(2) Сургалтын тухай ерөнхий зөвлөгөө авах

Ажлын өдөр: (Даваа-Баасан): 09:00 - 18:00

Сар бүрийн 3 дахь долоо хоногийн бямба гараг : 09:00 - 17:00

Биеэр ирж зөвлөгөө авах бол дараах утсаар урьдчилан цаг авна уу. Утас : 0120-53-8288

* Гадаад хүүхэд, сурагчийн ахлах сургуульд элсэн орох тухай болон сургалын тухай орчуулагчтай зөвлөгөө авах бол долоо хоног бүрийн баасан гарагт 13:00 - 17:00 хүртэл (хүлээн авах цаг 16:00 хүртэл)

* Үйлчилгээ үзүүлэх хэл: Япон хэл, англи хэл, хятад хэл, солонгос - хойд солонгос хэл

Амьжиргааны дэмжлэг

- ["Life in Tokyo: Your Guide"](#) (Токио хотын аж ахуй соёлын товчоо)

Токио хотод анх удаа амьдрах гэж буй гадаад иргэнд зориулсан аж ахуйн тухай мэдээллийн гарын авлага.

Үйлчилгээ үзүүлэх хэл: Япон хэл, англи хэл, хятад хэл, солонгос - хойд солонгос хэл

- [Гадаадын иргэдийн амьдралыг дэмжих портал цахим хуудас](#) (Хуульзүйн яам Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газар)

Япон улсад оршин суухад мэдүүштэй хэрэгцээт мэдээллийг оруулсан портал сайт.

Үйлчилгээ үзүүлэх хэл: Япон хэл, хялбар япон хэл, англи хэл, хятад хэл, солонгос хэл, испани хэл, португал хэл, вьетнам хэл, непал хэл, тайланд хэл, индонез хэл, мянмар хэл, кхмер (комбож хэл), филиппин хэл, монгол хэл

Хот дүүрэг захиргааны Боловсролын зөвлөлийн ажилтанд чиглэсэн холбоос

Гадаад хүүхэд хүлээж авах

- [Гадаад хүүхдэд зориулсан элсэлтийн гарын авлага](#) (Боловсрол, соёл спорт, шинжлэх ухааны яам)

Япон сургуулиудад зориулсан олон улсын хэл дээрх элсэлтийн гарын авлага.

Үйлчилгээ үзүүлэх хэл: Англи хэл, өмнөд солонгос – хойд солонгос хэл, вьетнам хэл, филиппин хэл, хятад хэл, португал хэл, испани хэл

- [Гадаад хүүхэд хүлээж авах тухай гарын авлага](#) (Боловсрол, соёл спорт, шинжлэх ухааны яам)

Гадаад хүүхэд Японы сургуульд асуудалгүй элсэн ороход зориулсан гарын авлага.

- [CASTA-NET](#) (Боловсрол, соёл спорт, шинжлэх ухааны яам)

Гадаад улстай холбоотой хүүхэд, сурагчийн суралцах орчинг дэмжих мэдээллийн цахим сайт.

Япон хэлний сургалт

- [Япон хэлний сургалтын гарын авлага](#) (Токио хотын боловсролын зөвлөл)

Япон хэл суралцах шаардлагатай гадаад хүүхэд, сурагчид зориулсан япон хэлний гарын авлага.

- [Гадаад хүүхэд, сурагчдад зориулсан япон хэлний гарын авлага “Таношии Гакко”](#) (Токио хотын боловсролын зөвлөл)

Япон хэл сурах шаардлагатай гадаад хүүхэд, сурагчдад чиглэсэн олон улсын хэл дээрх япон хэл болон сургуулийн орчны тухай гарын авлага.

Үйлчилгээ үзүүлэх хэл: Хятад хэл, филиппин хэл, өмнөд солонгос - хойд солонгос хэл, англи хэл, испани хэл, тайланд хэл, португал хэл, мянмар хэл, вьетнам хэл, монгол хэл, орос хэл, перс хэл, араб хэл, франц хэл, лаос хэл, румын хэл, непал хэл, бенгал хэл, хинди хэл, индонез хэл, турк хэл, синхал хэл

Холбоо барих

“Улсын бага, дунд сургуулийн ерөнхий боловсролын тухай”

Боловсролын Газар, Бүс нутгийн боловсролыг дэмжих хэлтэс, Ерөнхий боловсролын тасаг, Бага дунд сургууль хариуцсан ажилтан

И-мэйл хаяг: S8000810(at)section.metro.tokyo.jp

Хамааралгүй майл ирэхээс сэргийлэн майл хаягт өөрчлөлт оруулан бичсэн байгаа.

Та цахим шуудан явуулахдаа (at) хэсгийг @ -р сольж бичнэ үү.